



МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Хэвлэмэл хуудасны индекс батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 4.2.5, 4.2.6, Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Салбарын хяналтын газарт хэрэглэх хэвлэмэл хуудасны индексийг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар /Д.Жаргал/-т даалгасугай.



Ц.ДАВААСҮРЭН

152310128

Барилга, хот байгуулалтын сайдын
2023 оны 03 дугаар сарын
10-ны өдрийн 13 дугаар
тушаалын хавсралт

Хэвлэмэл хуудасны индекс

Д/д	Хэвлэмэл хуудасны нэр төрөл	Бүсчлэлийн код	Салбарын код	Хэвлэмэл хуудасны индекс
1	2	3	4	5
Нэг. Захирамжлалын баримт бичгийн хэвлэмэл хуудас				
1.	Салбарын улсын ерөнхий байцаагчийн албан даалгавар	15	02	01
2.	Салбарын улсын ерөнхий байцаагчийн шийдвэр			02
3.	Улсын ахлах байцаагчийн албан даалгавар			03
4.	Улсын ахлах байцаагчийн шийдвэр			04
5.	Улсын ахлах байцаагчийн албан шаардлага			05
6.	Улсын байцаагчийн албан шаардлага			06
Хоёр. Зохион байгуулалтын баримт бичгийн хэвлэмэл хуудас				
7.	Албан бичгийн А4	15	02	07
8.	Албан бичгийн А5			08
9.	Хяналт шалгалтын удирдамж			09
10.	Улсын ахлах байцаагчийн акт			10
11.	Улсын ахлах байцаагчийн дүгнэлт			11
12.	Улсын ахлах байцаагчийн зөвлөмж			12
13.	Улсын байцаагчийн акт			13
14.	Улсын байцаагчийн дүгнэлт			14
15.	Улсын байцаагчийн зөвлөмж			15
16.	Хурлын тэмдэглэл			16
17.	Хурлын тэмдэглэлийн шийдвэр			17
Гурав. Мэдээлэл лавлагааны баримт бичгийн индекс				
18.	Хяналт шалгалтын танилцуулга	15	02	18

--- oOo ---

МУ-ын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" –ын

4.2.5. Байгууллага нь хэвлэмэл хуудсыг нэр төрлөөр нь ангилан, баримт бичгийн стандартад заасны дагуу хэвлэмэл хуудасны баруун доод өнцөгт, доод захаасаа 10 мм, баруун захаасаа 15 мм-ийн зай авч, хөх өнгийн бэх бүхий тусгай дугаарлагчаар дугаарлах бөгөөд энэ дугаарыг хэвлэмэл хуудасны индекс гэнэ.

4.2.6. Хэвлэмэл хуудасны индекс нь 9-10 оронтой тооноос бүрдэнэ:

00 00 00 0000;

00-Бүсчлэлийн код-тухайн байгууллагын байрлаж буй нутаг дэвсгэрийн бүсчлэлийн кодын эхний 2 тоо; (15)

00-Салбарын ангиллын код-Салбарын дээд байгууллагаас харьяа газар, байгууллагыг ангилж олгосон тоо (ангилалгүй тохиолдолд бүсчлэлийн кодын 5 оронтой тоог, эсхүл тухайн оны сүүлийн 2 орныг бичих); он (23)

00-Хэвлэмэл хуудасны нэр төрлийн дугаар-байгууллагын даргын тушаалаар хэвлэмэл хуудсыг ач холбогдол, нэр төрлөөр ангилан олгосон тоо; (01)

0000-Хэвлэмэл хуудасны дараалсан дугаар;

Жишээ нь: 17 52 01 0001-салбарын ангилалтай бол

17 21 01 0001-салбарын ангилалгүй бол

17 20 01 0001

Салбарын хяналтын газар -15 23 01 0001